



БУЛГАН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ  
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

# БУЛГАН АЙМГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН байдал

Monthly bulletin of **STATISTICS**

2018/7  
[www.bulgan.nso.mn](http://www.bulgan.nso.mn)



# СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙГ ХЭРХЭН АВАХ ВЭ?

**www.1212.mn**

СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН  
НЭГДСЭН САН

www.nso.mn сайтын  
Хэрэглэгчийн бүртгэлд  
бүртгүүлснээр цахим  
хаягаар тогтмол  
авч болно.

Monstat ezStat  
аппликейш

1900-1212  
Лавлах утас

@statistic\_mn

Статистик  
мэдээлэл

Вндэсний Статистикийн  
Хорооны  
НОМЫН САН

Онлайн лавлах  
мессенжер  
8:30-17:30

**ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ**

**ХҮНД СУРТАЛ  
АВИЛГА**

**ҮГҮЙ НЭЭЛТТЭЙ  
ХҮРГЭНЭ**

## ГАРЧИГ

Аргачлалын тайлбар.....	2
Товч танилцуулга.....	6
I. 1 Хүн ам.....	11
I. 2 Хөдөлмөр.....	12
I. 3 Нийгмийн халамж.....	13
I. 3 Нийгмийн даатгал.....	13
I. 4 Эрүүл мэнд .....	14
I. 6 Гэмт хэрэг .....	14
II.3 Үнэ.....	16
II.7 Аж үйлдвэр.....	21
II.14 Мал аж ахуй.....	22

## Аргачлалын тайлбар

### Хөдөлмөр

Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхлэгдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхитэй хайж байгаа хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, хөдөлмөрийн төв бирж, хөдөлмөрийн хувийн биржид бүртгүүлсэн ажилгүй иргэдийг хамруулна.

### Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгал нь иргэн болон төр, аж ахуйн нэгж байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, даатгуулах, өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, өвчлөх, ажилгүй болоход өөрт нь, тэрчлэн даатгуулагч нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх агуулга бүхий нийгэм эдийн засгийн арга хэмжээ юм. Тэтгэврийн, тэтгэмжийн, эрүүл мэндийн, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалан өвчний, ажилгүйдлийн даатгал гэсэн төрлөөс нийгмийн даатгал бүрдэнэ.

Нийгмийн даатгалын сан нь ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах болон нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

Нийгмийн даатгалын тухай хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг даатгуулагчаар тооцно.

Тэтгэвэр нь даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөгжлийн бэрхшээлтэй болоход хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, нас барахад нь түүний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд (хүүхэд 16 нас, сургуульд суралцаж байгаа бол 19 нас хүртэл)-ийн нийгмийн баталгааг хангах зорилгоор нийгмийн даатгалын сангаас олгох мөнгөн хөрөнгө байна.

Тэтгэмж нь хөдөлмөрийн чадвараа түр алдах, жирэмслэх, амаржих, нас барах тохиолдолд даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас нэг удаа олгох мөнгөн хөрөнгө байна.

Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай хүнд хуульд заасан тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.

### Эрүүл мэнд

Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байвал хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүйгээр амьд төрөлтөд тооцно.

Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг тодорхойлохдоо тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулна.

Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох хүүхдийн эндэгдлийг тооцохдоо тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд хуваана.

Эндсэн эхийн тоонд жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэн эхийг хамааруулна.

Халдварт өвчний өвчлөлийн 10000 хүнд ногдох түвшинг тооцохдоо тайлант хугацаанд амбулаторийн үзлэгээр шинээр бүртгэгдсэн нийт халдварт өвчний тохиодлын тоог тухайн хугацааны хүн амын тоонд харьцуулна.

### Аюулт үзэгдэл, осол

Гамшиг гэж аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг хэлнэ.

Аюулт үзэгдэл гэж хүчтэй цасан болон шроон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах зэргийг хамруулан ойлгоно. Техникийн холбогдолтой осол гэж үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөнөөс тоног төхөөрөмж, барилга, байгууламж, шугам, сүлжээ эвдрэх, тээврийн хэрэгсэл осолдох, сүйрэх, цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдах зэргийг хамруулан ойлгоно.

### Гэмт хэрэг

Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан, нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ.

Гэмт хэргийн нийгмийн шинж чанар, аюулын хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд хөнгөнийг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна.

Гэмт хэргийн тоог Монгол Улсын Эрүүгийн хуульд заасны дагуу гэмт хэргийн төрлөөр нэгтгэн гаргаж байна.

Тухайлбал:

- Хүний ам бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг
- Хүүхэд гэр бүл, нийгмийн эсрэг гэмт хэрэг
- Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг
- Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг
- Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг
- Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг
- Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг
- Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг
- Бусад гэмт хэрэг

18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог тодорхойлохдоо нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог 18 ба түүнээс дээш насны хүн амын дундаж тоонд харьцуулна.

Дор дурьдсан этгээдэд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч эрүүгийн хэрэг үүсгэж, үндэслэл бүхий тогтоол гаргасан бол сэжигтнээр тооцно. Үүнд:

-Уг этгээдийг гэмт хэрэг үйлдэж байх үед буюу үйлдэл дор нь барьсан

-Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хохирогч буюу харсан хүн шууд заасан

-Уг этгээдийн бие, хувцас, эд зүйл, орон байранд гэмт хэргийн ул мөр тодорхой илэрч олдсон

-Уг этгээд хэргээ илчлэн ирсэн

-Гэмт хэрэгт сэрдэгдэх үндэслэл бүхий бусад баримт байгаа бол

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч тогтоол үйлдэж, ял сонсгосон этгээдийг яллагдагчаар тооцно.

### Төрийн санхүү

Орон нутгийн төсвийн суурь орлого гэж тухайн шатны төсөвт орох татварыг доод хувь хэмжээгээр тооцсон орлого болон татварын бус орлогын нийлбэрийг хэлнэ.

Орон нутгийн суурь зарлага гэж сум, аймаг, нийслэлийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй холбогдох урсгал болон хөрөнгийн зарлага, нийгмийн асрамж, халамжийн үйлчилгээ, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлыг хэлнэ.

Төсвийн тэнцэл гэж тухайн төсвийн жил, улирлын нийт орлого, зарлагын зөрүүг хэлнэ.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлан аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга бүрдүүлж зарцуулах төсөв нь орон нутгийн төсөв байна.

Татварын орлогод орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэл, хураамж, өмчийн татвар, дотоодын бараа, үйлчилгээний татвар, гадаад худалдааны татварын орлого болон бусад татвар орно.

Төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг, хүү, торгуулийн орлого, түрээсийн орлого, төсөвт газрын өөрийн орлого болон татварын бус бусад орлогоос татварын бус орлого бүрдэнэ.

Төсвийн зарлагыг урсгал зардал, хөрөнгийн зардал, цэвэр зээл гэж ангилна.

Бараа, үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба урсгал шилжүүлгээс урсгал зардал бүрдэнэ.

### Үнэ

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ) нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн

өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

ХҮИ-ийн тооцоонд хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашиглана.

Хэрэглээний сагс нь дундаж зарлагатай өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хэрэглээний үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тооцоход бараа, үйлчилгээний тоо хэмжээ, төрөл, чанар зэргийг тогтмолоор авч үздэг.

Хэрэглээний бараа үйлчилгээний жин гэж өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувийн жин юм.

ХҮИ-ийн тооцоонд Ласпейресийн үнийн индексийн томъёог ашиглаж болно.

$$I_p^L = \frac{\sum_{i=1}^n p_{it} * q_{io}}{\sum_{i=1}^n p_{io} * q_{io}}$$

$I_p^L$  -  $t$  тайлант үеийн Ласпейресийн үнийн индекс

$t$  - тайлан үе

$o$  - суурь үе

$p_{it}$  - 'i' барааны тайлант үеийн үнэ,

$p_{io}$  - 'i' барааны суурь үеийн үнэ,

$q_{io}$  - 'i' барааны суурь үеийн худалдан авсан тоо, хэмжээ,

$\sum$  - нийлбэрийн тэмдэг

### Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл нь аж ахуйн нэгжүүдийн тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгжүүдийн

тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар нь ангилахдаа НҮБ-аас гишүүн орнууддаа мөрдөхийг зөвлөмж болгосон эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны олон улсын стандарт ангилалд үндэслэсэн үндэсний ангиллыг мөрдөж байна.

### Ерөнхий тэмдэглэл

I. Саруудыг ром тоогоор тэмдэглэв (I, II, III, IV, V, ... гэх мэт)

Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдэх дүнг харуулахдаа I-IV, I-X зэргээр илэрхийлэв.

II. Дараах тэмдэглэлийг ашиглав:

... мэдээлэл байхгүй

0.0 маш бага тоо

- гүйцэтгэл байхгүй

III. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.

## I. Нийгмийн үзүүлэлт




### I.1 Хүн ам

2018 оны 7-р сарын байдлаар иргэний бүртгэлд шинээр төрсөн 690 хүүхэд, нас барсан 216 хүний бүртгэлийг бүртгэсэн нь өмнөх оны мөн үеийнхээс шинэ төрсөн хүүхэд 21 буюу 3.4 хувиар, нас баралт 11 буюу 5.1 хувиар тус тус өсжээ.

Зураг I.1.2


Бүртгэгдсэн төрөлт, нас баралт



7-р сарын байдлаар 625 хүн шилжин ирж, 696 хүн шилжин явсан нь өмнөх оны мөн үеийнхээс шилжин ирсэн хүн 112 буюу 17.9 хувиар, шилжин явсан хүн 122 буюу 17.5 хувиар тус тус өссөн байна.

Зураг I.1.3

Бүртгэгдсэн шилжих хөдөлгөөн



### I.2 Бүртгэлтэй, ажилгүй иргэн

Аймгийн хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй ажилгүй иргэн 425 болсны 243 нь эмэгтэй байна. Хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй иргэдийн 14.8 хувийг бакалаврын болон дипломын боловсролтой, 3.1 хувийг тусгай мэргэжлийн дунд, 4.2 хувийг техникийн болон мэргэжлийн, 64.7 хувийг бүрэн дунд боловсролтой, 8.0 хувийг суурь боловсролтой, 4.0 хувийг бага боловсролтой, 1.2 хувийг боловсролгүй иргэд эзэлж байна

Зураг I.2.1

Ажлын шинэ байранд болон ажилд зуучлагдан орсон иргэд



Аймгийн хэмжээнд ажил хайгч иргэдийн 15.5 хувийг 15-24 насны, 30.5 хувийг 25-34 насны, 28.9 хувийг 35-44 насны, 20.9 хувийг 45-54 насны, 2.9 хувийг 55-59 насны, 1.3 хувийг 60-аас дээш насны хүмүүс эзэлж байна.

Зураг I.2.2

Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшнээр



### I.3. Нийгмийн даатгал, халамж Нийгмийн даатгал

Нийгмийн даатгалын сангийн орлого 2018 оны 7-р сарын байдлаар 5630.1 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 1386 сая төгрөг буюу 19.8 хувиар буурч, зарлага 20734.3 сая төг болж өмнөх оны мөн үеэс 679 сая төг буюу 3.4 хувиар өссөн байна.

Нийгмийн даатгалын сангийн орлого өмнөх оны мөн үеэс буурсан шалтгаан нь эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлага

шивэгдээгүйтэй холбоотой.

Тэтгэврийн даатгалын сангийн орлого өмнөх оны мөн үеэс 569.9(13.8%) сая төгрөгөөр, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангийн орлого 21.7(7.4%) сая төгрөгөөр өсч, тэтгэмжийн даатгалын сангийн орлого 8.4(1.6%) сая төгрөгөөр, ажилгүйдлын даатгалын сангийн орлого 19.1(15.7%) сая төгрөгөөр буурсан голлон нөлөөлсөн байна.

Нийгмийн даатгалын сангийн зарлага 2018 оны 7-р сарын байдлаар 20734.3 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага 46.7(19.4%) сая төгрөгөөр, буурсан хэдий ч тэтгэврийн даатгалын сангийн зарлага 2251.4(13.1%) сая төгрөгөөр, тэтгэмжийн даатгалын сангийн зарлага 85.7(13.2%) сая төгрөгөөр, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангийн зарлага 85.5(36.7%) сая төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлөв.

**Нийгмийн халамж**

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэдээллээр нийгмийн халамжийн сангаас 2018 оны 7-р сарын байдлаар 11107 хүн 2820.9 сая төгрөгийн тэтгвэр, тэтгэмж олгосон нь өмнөх оны мөн үеийнхээс нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж авагчид 179.6 сая.төг буюу 6.8 хувиар өсч, харин нийгмийн халамжийн тэтгэвэрт 1074 хүн хамрагдаж 1033.9 сая.төг олгосон нь өмнөх оны мөн үеийнхээс 75.3 сая.төг буюу 7.9 хувиар өссөн байна.

Нийгмийн халамжийн үйлчилгээ, хөнгөлөлтөд 2018 оны 7-р сарын байдлаар 7472 хүн хамрагдсаны 20.6 хувь нь нийгмийн халамжийн хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламжид хамрагдсан иргэд, 16.4 хувь ахмад настан, 2.0 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд, 60.6 хувь хүнс тэжээл хөтөлбөр хамрагдсан байна. Нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлтөд 1026.2 сая.төг олгосон нь өмнөх оны мөн үеийнхээс 279.8 сая.төг буюу 37.5 хувиар өссөн байна.




**1.4 Эрүүл мэнд**

Аймгийн хэмжээнд 2018 оны 7-р сарын байдлаар 459 эх амаржиж, амьд төрсөн хүүхдийн тоо 464 болж, өмнөх оны мөн үеийнхээс амаржсан эх 23 буюу 5 хувиар, амьд төрсөн хүүхдийн тоо 24 буюу 5 хувиар тус тус буурсан байна.

**Зураг I.4.1**


Амаржсан эх, амьд төрсөн хүүхэд,



Нялхасын эндэгдэл 2018 оны эхний -р сарын байдлаар 12 бүртгэгдсэн байна.

**Зураг I.4.2**

Эндсэн хүүхэд



Халдварт өвчнөөр өвчлөгсөд 2018 оны 7-р сарын байдлаар 249 болж, өмнөх оны мөн үеийнхээс 70 тохиолдол буюу 22 хувиар буурсан байна. Нийт халдварт өвчнөөр өвчлөгсдийн 95 буюу 38.1 хувь нь амьсгалын замын халдварт өвчин, 100 буюу 40.1 хувь нь бэлэгсийн замын халдварт өвчнөөр өвчилсөн байна.

**Зураг I.4.3**

Халдварт өвчнөөр өвчлөгсөд






### I.6 Гэмт хэрэг

Аймгийн хэмжээнд 2018 оны 7-р улирлын байдлаар 163 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 38 хэргээр буюу 18.7 хувиар буурсан байна.

**Зураг I.6.1**

Бүртгэгдсэн гэмт хэрэг




Хэргийн өнгөөр нь авч үзвэл:

- Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 18 бүртгэгдэж 7 хэргээр буюу 63.6 хувиар
- Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх гэмт хэрэг 10 бүртгэгдэж 3 хэргээр буюу 42.8 хувиар
- Залилах гэмт хэрэг 2 бүртгэгдэж 1 дахин тус тус өссөн бол
- Хулгайлах гэмт хэрэг 55 бүртгэгдэж 23 хэргээр буюу 29.4 хувиар
- Мал хулгайлах хэрэг 14 бүртгэгдэж 5 хэргээр буюу 26.3 хувиар
- Хүнийг санаатай алах гэмт хэрэг бүртгэгдээгүй буюу 1 дахин
- Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 49 бүртгэгдэж 14 хэргээр буюу 22.2 хувиар
- Хөдөлгөөний аюулгүй байдал тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 12 бүртгэгдэж 6 хэргээр буюу 33.3 хувиар тус тус буурсан байна.

Гэмт хэргийн улмаас нийт иргэд, аж ахуй нэгж байгууллагад 417.4 сая төгрөгний хохирол учирснаас иргэдэд 384.6 сая төгрөгний хохирол учирсан байна. Үүнээс бүртгэлд мөрдөн байцаалтын шатанд нийт хохирлын 34.8 хувь буюу 154.4 сая төгрөгний хохирлыг нөхөн төлүүлж ажилласан.

**Зураг I.6.2**

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, жил бүрийн 7-р сарын байдлаар



Гэмт хэргийн улмаас 11 хүн нас барсан ба өнгөрсөн оны мөн үеийнхээс 45 хувиар буурсан байна. Бусдыг амиа хорлоход хүргэсэн гэмт хэргийн улмаас 8 хүн, хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас 2 хүн амь насаа алдсан байна.

**Зураг I.6.3**

Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан, жил бүрийн 7-р сарын байдлаар



Хэргийн өнгөөр нь авч үзвэл: Гэмт хэргийн улмаас 61 хүн гэмтсэн нь ХЭМХБЭГХ-ийн улмаас 51, ХАБТХАЖЭГХ-ийн улмаас 7 хүн, бусад хэргийн улмаас 3 хүн гэмтсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 22.7 хувиар буурсан байна.

Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 22 бүртгэгдэж 20 хэргээр буюу 47.6 хувиар буурсан.

Нийт 16 хэргийг бүлгээр үйлдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 3 хэргээр буюу 23 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

72 гэмт хэрэгт 111 хүн холбогдсон нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 55 хүнээр буюу 33.1 хувиар буурсан байна.




## II. Эдийн засгийн үзүүлэлт

### II.1 Аймгийн төсөв

Аймгийн төсвийн нийт орлого 2018 оны 7-р сарын байдлаар 33071.9 сая төгрөг, зарлага 32353.2 сая төгрөг болж, аймгийн төсвийн нийт тэнцэл 718.7 сая төгрөгний эерэг гарлаа.

**Зураг II.1.1**


Аймгийн төсвийн орлого, зарлага  
сая төг



Орон нутгийн төсвийн орлогын 36.8 хувийг татварын орлого. 4.6 хувийг татварын бус орлого. 58.4 хувийг улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг эзэлж байна. Төсвийн зарлага 2018 оны 7-р сарын байдлаар 32353.2 сая.төг болоход 74 хувийг бараа ажил үйлчилгээний зардал. 12.3 хувийг урсгал шилжүүлгийн зардал эзэлж байна.

**Зураг II.1.2**

Аймгийн төсвийн өр, авлага  
сараар



Нийт өр 220.9 сая төгрөг байна. Өмнөх сараас 12.8 сая төгрөгөөр, өмнөх оны мөн үетэй харьцуулбал 12.0 сая төгрөгөөр тус тус буурсан байна. Цалин, НДШ-ийн өглөг 65.2 сая, халаалт, гэрэл цахилгаан, цэвэр бохир усны өглөг 95.2 сая, эмийн өр 26.1 сая, бусад зардлын өр 34.4 сая төгрөг байна. Сайдын багцаар авч үзвэл Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын байгууллагууд 101.5 сая, орон нутгийн байгууллагууд 79.4 сая, Эрүүл мэндийн сайдын байгууллагууд 40.0 сая төгрөгийн өртэй байна.



**II.3 Үнэ**


**Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ**

Хэрэглээний бараа, үйлчилгээний

үнийн индекс аймгийн хэмжээнд 2018 оны 7-р сарын байдлаар өмнөх оны мөн үеийнхээс 5.1 хувиар, сарын эхнээс 4.7 хувиар, өмнөх сарынхаас 0.6 хувиар өссөн байна.

**Зураг II.3.1**

Хэрэглээний бараа үйлчилгээний үнийн индекс, хувь, 2018 IV сар, (өмнөх сар=100%)



**Хүснэгт II.3.1**

Хэрэглээний бараа үйлчилгээний үнийн индекс, хувь, 2018 VII сар(өмнөх сар=100%)

Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	2018 VII 2017 VII	2018 VII 2017 XII	2018 VII 2018 VI
Ерөнхий индекс	100.0	105.1	104.7	100.6
Хүнсний бараа, ундаа, ус	29.3	105.5	107.3	99.4
Согтууруулах ундаа, тамхи	3.2	102.7	102.3	100.0
Хувцас, бөс, бараа, гутал	16.1	101.2	101.5	100.6
Орон сууц, ус, цахилгаан, түлш	12.3	98.8	97.4	99.9
Гэрэхүйн тавилга, бараа	4.7	105.3	103.2	101.0
Эм тариа, эмнэлэгийн үйлчилгээ	3.6	118.1	116.3	104.0
Тээвэр	12.2	109.2	106.8	101.6
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	100.0	100.0	100.0
Амралт, чөлөөлт цаг, соёлын бараа, үйлчилгээ	2.8	120.4	120.1	100.0
Боловсролын үйлчилгээ	4.7	100.1	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	2.6	100.0	100.0	100.0
Бусад бараа, үйлчилгээ	4.1	107.7	104.9	102.0

**II.5 Малын дундаж үнэ**

Мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн судалгаагаар 2018 оны 7 сарын байдлаар үхрийн 1.8-2.3 м урттай шир 5.0 мян.төгрөг, 2.3 м-с дээш урттай шир 7.5 мян. төгрөг, адууны шир, хонины нэхий, ямааны арьс нь зах зээлд нийлүүлэлт байхгүй болсон байна. Өмнөх оны мөн үеийнхээс үхрийн 1.8-2.3 метрийн урттай шир 54.5 хувиар, 2.3 метрийн урттай шир 54.5 хувиар тус тус буурсан байна.

Малын дундаж үнэ: 2018 оны эхний 7 сарын байдлаар тэмээ 900.0 мян.төг, адуу 604.0 мян.төг, үхэр 780.0 мян.төг, хонь 111.0 мян.төг, ямаа 80 мян.төг болж буюу өмнөх

оны мөн үеийнхээс үхэр 0.9 хувиар, ямаа 4.6 хувиар өссөн бол тэмээ 1.4 хувиар, адуу 3.1 хувиар, хонь 1.2 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.




### II.6 Аж үйлдвэр

Аймгийн аж үйлдвэрийн газрууд 2018 оны энхий 7 сарын байдлаар 2182.1 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 3520.5 сая төгрөгийн борлуулалт нийсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад үйлдвэрлэлт 15.3 хувиар өсч, борлуулалт 17.8 хувиар буурсан байна. Өмнөх оноос борлуулалт буурсан шалтгаан нь аймгийн хэмжээнд үйлдвэрлэлт явуулдаг Хангайн гурил ХХК, ИНТОСЭ ХХК гурилын үйлдвэр үйлдвэрлэлт байхгүй, Орхон мандал ХХК урьд оноос эрс бага 2017 онд гантай байснаас ургац алдаж будаа муутай үйлдвэрлэлт муу байгаас шалтгаалж байна.

Зураг II.6.1

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлт, борлуулалт




### II.14 Хөдөө аж ахуй

#### Мал төллөлт, төл бойжилт

Аймгийн хэмжээнд 2017 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 1520.9 мянган хээлтэгч малын 1034.4 мянга буюу 68.0 хувь нь 2018 оны энхий 7 сард төллөсөн байна. Эм ямааны 67.2 хувь, эм хонины 72.3 хувь, ингэний 39.1 хувь, үнээний 56.8 хувь, гүүний 45.7 хувь төллөжээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулвал мал төллөлт 14.3 пунктээр буурсан үзүүлэлттэй байна. Гарсан төлийн 97.2 хувь буюу 1005.0 мянган төл бойжиж байгаа нь өмнөх оны мөн үеийнхтэй ижил хувьтай байна.

Зураг II.14.2

Том малын зүй бусын хорогдол




■ Адуу ■ Үхэр ■ Хонь ■ Ямаа ■ Тэмээ

Том малын зүй бусын хорогдол 2018 оны энхий 7 сарын байдлаар 104.3 мян.толгой болж, өмнөх оны мөн үеийнхээс 40.8 мян. толгой мал буюу 39.1 хувиар өссөн байна. Нийт хорогдлыг малын төрлөөр авч үзвэл адуу 15.7 мянга буюу 15 хувь, үхэр 22.3 мянга буюу 21.3 хувь, хонь 38.2 мянга буюу 36.6 хувь, ямаа 28.1 мянга буюу 26.99 хувь, тэмээ 6 буюу 0.01 хувь буюу оны энхий малын 3.1 хувь нь тус тус хорогдоод байна. Нийт хорогдлын дийлэнх 63.6 хувийг ямаа, хонь эзэлж байна. Хорогдлыг сумаар авч үзвэл Могод сум 25.6 хувийг, Гурванбулаг сум 19.6 хувь, Хишиг-Өндөр сум 12.9 хувийг тус тус эзэлж байгаа нь дийлэнх болж байна.

Зураг II.14.1

Зүй бусаар хорогдсон том мал, сумаар, 7 сарын байдлаар, толгой



## II.16 Газар тариалан

2018 оны хагас жилийн байдлаар аймгийн хэмжээнд нийт 48214.58 га талбайд тариалалт хийсэн байна. Үүнээс үр тариа 42259.1 га, төмс 251.18 га, хүнсний ногоо 149.5 га, техникийн ургамал 4641.2 га, тэжээлийн ургамал 910.5 га, эмийн ургамал 3.1 га талбайд тус тус тариалтыг хийжээ.

### Зураг II.16.1

Үр тариа, төмс, хүнсний ногооний тариалсан талбай жил бүрийн эхний хагас жилийн байдлаар



Тариалсан талбай өнгөрсөн оны мөн үеийхээс 0.7 хувиар буюу 344.6 га-гаар буурсан. Үүнээс: үр тариа 733.6 га буюу 1.7 хувь, төмс 131.7 га буюу 34.4 хувь, эмийн ургамал 250.4 га буюу 98 хувь, тус тус буурсан бол, Хүнсний ногоо 3.39 га буюу 2.3 хувь, тэжээлийн ургамал 622.5 га буюу 3.1 дахин, техникийн ургамал 145.2 га буюу 3.2 хувиар тус тус өссөн байна.

### Зураг II.16.2

Тариалсан талбай төрлөөр




I.I ХҮН АМ

Хүснэгт I.I.1 Хүн ам, өрх

Сум	Хүн ам			2017 2016	Эрэгтэй			2017 2016	Эмэгтэй			2017 2016
	2015	2016	2017		2015	2016	2017		2015	2016	2017	
Баян-Агт	3052	3119	3218	102.2	1550	1583	1632	102.1	1502	1536	1586	102.3
Баяннуур	1868	1818	1861	97.3	983	969	998	98.6	885	849	863	95.9
Бугат	2182	2241	2277	102.7	1132	1187	1208	104.9	1050	1054	1069	100.4
Булган	12234	12512	12616	102.3	6014	6104	6125	101.5	6220	6408	6491	103
Бүрэгхангай	2726	2832	2888	103.9	1388	1459	1482	105.1	1338	1373	1406	102.6
Гурванбулаг	3133	3176	3219	101.4	1617	1644	1660	101.7	1516	1532	1559	101.1
Дашинчилэн	2803	2941	3037	104.9	1431	1492	1540	104.3	1372	1449	1497	105.6
Могод	2685	2701	2729	100.6	1375	1383	1394	100.6	1310	1318	1335	100.6
Орхон	3482	3584	3595	102.9	1865	1911	1913	102.5	1617	1673	1682	103.5
Рашаант	3141	3165	3215	100.8	1583	1602	1618	101.2	1558	1563	1597	100.3
Сайхан	3575	3648	3662	102	1816	1854	1871	102.1	1759	1794	1791	102
Сэлэнгэ	3207	3306	3332	103.1	1666	1723	1733	103.4	1541	1583	1599	102.7
Тэшиг	3495	3504	3563	100.3	1786	1782	1820	99.8	1709	1722	1743	100.8
Хангал	4548	4611	4704	101.4	2282	2302	2343	100.9	2266	2309	2361	101.9
Хишиг-Өндөр	3154	3156	3158	100.1	1592	1595	1592	100.2	1562	1561	1566	99.9
Хутаг-өндөр	4729	4835	4952	102.2	2432	2487	2546	102.3	2297	2348	2406	102.2
Нийт хүн ам	60014	61149	62026	101.9	30512	31077	31475	101.9	29502	30072	30551	101.9

Зураг I.I.1 Хүн амын нас хүйсийн суварга 2017 он



## I.2 ХӨДӨЛМӨР

## Хүснэгт I.2.1 Хөдөлмөр

Үзүүлэлт	2017 VII		2018 VII		2018 VII % 2017 VII	
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй
Ажил хайгч иргэн /сарын эцэст/	739	362	689	369	93.2	101.9
Бүртгэлтэй ажилгүй иргэн /сарын эцэст/	483	258	425	243	88.0	94.2
Ажилд зуучилсан иргэн /эдийн засгийн салбараар/	278	125	848	323	305.0	258.4
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан, агнуур	87	20	212	71	243.7	355.0
Уул уурхай олборлолт	6	1	58	7	966.7	-
Боловсруулах үйлдвэр	5	3	21	7	420.0	233.3
Цахилгаан, хий, уур, агааржуулалт			19	0	-	-
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	5	4	12	11	240.0	275.0
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, холбоо мэдээлэл	2	1	3	1	-	-
Зочид буудал, байр, сууц болон нитийн хоолны үйлчилгээ	2	1	8	7	400.0	700.0
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	42	19	11	9	26.2	47.4
Боловсрол	22	14	65	47	295.5	335.7
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	7	4	14	12	200.0	300.0
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа					-	-
Бусад	100	58	425	151	425.0	260.3
Ажил хайгч иргэн (насны бүлгээр)	483	258	425	243	88.0	94.2
15-24	99	54	66	42	66.7	77.8
25-34	155	84	126	73	81.3	86.9
35-44	122	71	125	72	102.5	101.4
45-54	90	45	85	48	94.4	106.7
55-59	15	4	13	6	86.7	150.0
60+	2		10	2	500.0	-
Ажил хайгч иргэн (боловсролын түвшнээр)	483	258	425	243	88.0	94.2
Магистр, доктор	2	2			-	-
Дипломын болон бакалаврын дээд	94	61	63	44	67.0	72.1
Тусгай мэргэжлийн дунд	14	7	13	8	92.9	114.3
Техникийн болон мэргэжлийн	18	11	18	8	100.0	72.7
Бүрэн дунд	306	156	275	158	89.9	101.3
Суурь	40	19	34	15	85.0	78.9
Бага	4	1	17	8	425.0	800.0
Боловсролгүй	5	1	5	2	100.0	-

## I.3. НИЙГМИЙН ХАЛАМЖ

## Хүснэгт I.3.2 Нийгмийн халамжийн зарлага, хамрагдсан хүн

	Хүний тоо		Олгосон тэтгэвэр, тэтгэмж, мян. төг		2018 VII 2017 VII
	2017 I-VII	2018 I-VII	I-VII	I-VII	
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	8647	11107	2641350.7	2820960.2	106.8
Халамжийн тэтгэвэр	1095	1074	958670.1	1033979.2	107.9
Нөхцөлт мөнгөн тэтгэмж	3433	2561	936334.0	760800.9	81.3
Үүнээс:					
Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн	1864	1036	330039.7	124227.8	37.6
Ахмад настныг асарч буй иргэний	921	938	357564.8	390637.2	109.2
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг	394	368	148126.1	152502.0	103.0
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг	229	193	90053.4	82369.5	91.5
Бүтэн өнчин хүүхэд үрчлэн өсгөний	25	26	10550.0	11064.4	104.9
Нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлт	4119	7472	746346.6	1026180.1	137.5
Ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт тусламж	887	1226	150632.6	228598.2	151.8
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	154	153	58711.6	47887.6	81.6
Нийгмийн халамжийн хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж	1495	1537	360133.8	383208.9	106.4
Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ	12	27	2000.0	6100.0	305.0
Хүнс тэжээл хөтөлбөр	1,571	4,529	165631.2	351621.0	
Төрийн өмнөөс гүйцэтгэсэн ажил үйлчилгээ			9237.4	8764.4	94.9

## I.3. НИЙГМИЙН ДААТГАЛ

Үзүүлэлтүүд	2015 I-VII	2016 I-VII	2017 I-VII	2018 I-VII	2018 I-VII 2017 I-VII
Нийгмийн даатгалын сангийн орлого, сая.төг	<b>4223.1</b>	<b>6718</b>	<b>7016.1</b>	<b>5630.1</b>	<b>80.2</b>
Үүнээс:					
Тэтгэврийн даатгалын сан	2774.4	4090.2	4123.3	4693.2	113.8
Тэтгэмжийн даатгалын сан	315.3	454.9	526.7	518.3	98.4
Эрүүл мэндийн даатгалын сан	856.6	1718.8	1950.1		0.0
ҮОМШӨ*-ний даатгалын сан	204.2	348.9	294.3	316	107.4
Ажилгүйдлийн даатгалын сан	72.6	105.2	121.7	102.6	84.3
Нийгмийн даатгалын сангийн зарлага, сая.төг	<b>16637.7</b>	<b>18602.7</b>	<b>20055.3</b>	<b>20734.3</b>	<b>103.4</b>
Үүнээс:					
Тэтгэврийн даатгалын сан	14342.2	15713.4	17235.9	19487.3	113.1
Тэтгэмжийн даатгалын сан	644.4	622.4	649.3	735.0	113.2
Эрүүл мэндийн даатгалын сан	1246.8	1780.4	1696.9		0.0
ҮОМШӨ*-ний даатгалын сан	291.9	321.4	232.8	318.3	136.7
Ажилгүйдлийн даатгалын сан	112.4	165.1	240.4	193.7	80.6

## I.4 ЭРҮҮЛ МЭНД

**Хүснэгт I.4.1** Аймгийн хэмжээнд гарсан халдварт өвчин, өвчний төрлөөр оноор

Үзүүлэлт	2015 VII	2016 VII	2017 VII	2018 VII	2018/2017
Амаржсан эхийн тоо	614	536	482	459	95%
Амьд төрсөн хүүхэд	617	537	488	464	95%
Эхийн эндэгдэл	-	-	-	-	-
Амьгүй төрөлт	3	5	0	4	
Гэрийн төрөлт	1	1	3	2	67%
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	13	7	5	12	240%
Перинаталь эндэгдэл	11	8	4	12	300%
Амьд төрсөн 1000 хүүхэд тутмаас 1 хүртэл насанд эндсэн хүүхэд	21.1	13	10.2	25.9	254%

**Хүснэгт I.4.2** Аймгийн хэмжээнд гарсан халдварт өвчин, өвчний төрлөөр, оноор

Үзүүлэлт	2015 VII	2016 VII	2017 VII	2018 VII	2018/2017
Нийт гарсан халдварт өвчин	271	598	319	249	78%
Гэдэсний халдварт өвчин	7	0	5	31	620%
Амьсгалын замын халдварт өвчин	111	442	187	95	51%
Байгалын голомтот халдварт өвчин	1	10	12	6	50%
Бэлэгсийн замаар дамжих халдварт өвчин	136	124	99	100	101%
Арьсны халдварт өвчин	16	26	16	17	106%

## I.5 ГЭМТ ХЭРЭГ

**Хүснэгт I.4.1** Бүртгээгдсэн гэмт хэрэг, оноор, 7-р сарын байдлаар

Сум	2014 I-VII	2015 I-VII	2016 I-VII	2017 I-VII	2018 I-VII	2017 I-V % 2016 I-V
Булган	45	41	47	47	42	89.4
Баян-Агт	8	5	8	5	6	120.0
Баяннуур	4	5	4	4	6	150.0
Бугат	8	10	8	13	15	115.4
Бүрэгхангай	7	14	12	12	15	125.0
Гурванбулаг	6	9	5	8	6	75.0
Дашинчилэн	3	10	12	3	3	100.0
Могод	3	5	8	3	4	133.3
Орхон	6	12	18	24	16	66.7
Рашаант	6	5	2	10	4	40.0
Сайхан	6	2	9	9	7	77.8
Сэлэнгэ	4	1	3	15	8	53.3
Тэшиг	6	1	7	6	5	83.3
Хангал	8	1	2	14	3	21.4
Хишиг-Өндөр	8	7	4	11	5	45.5
